

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/001/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: [uvs@audit.mn](mailto:uvs@audit.mn)

Улаангом хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох  
Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор: Т.Золоо  
Цахим хаяг: Zoloot@audit.gov.mn

Т.Ариунсайхан  
Цахим хаяг: Ariunsaikhant@audit.gov.mn

Б.Нямбуу  
Цахим хаяг: Nyambuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Э.НАСАНБАТ ТАНАА

2026.04.20 № УВА-2026/00111А - СТА-ТЭШ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн "Аймгийн 2025 оны төсөвт зохицуулалт хийх тухай" 37 дугаар тогтоолоор аймгийн 2025 оны төсвийн орлого, зарлагыг 370.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд нэр заагдаагүй бусад орлогыг 370.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ОНХС болон их засвар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардалд өөрчлөлт оруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

8525050984

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

**АГУУЛГА**

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  - 3.5 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
- 4.7 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн талаар.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
ҮДТ	Үр дүнгийн тайлан
МГТ	Мөнгөн гүйлгээний тайлан
ӨӨТ	Өмчийн өөрчлөлтийн тайлан
ТГТ	Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		67,025,908.31	50,167,727.29
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	24,391,224.21	19,987,788.84
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	8,079,201.14	7,762,050.51
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	34,875	1,005.92
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	22,773,096.04	14,965,321.46
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	264,797	437,341.65
7	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	11,482,714.92	7,014,218.92
8	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		126,834,171.05	145,760,860.17
9	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	126,834,171.05	145,760,860.17
10	1.2.2.02 Биет хөрөнгө		116,385,966.36	135,416,340.46
11	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	10,448,204.69	10,344,519.71
12	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		193,860,079.36	195,928,587.46
13	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		8,212,308.88	9,772,536.92
14	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		7,133,629.16	8,777,120.92
15	2.1.1.03 Өглөг		7,111,375.63	8,744,394.59
16	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	22,253.53	32,726.32
17	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,078,679.71	995,416.01
18	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	1,078,679.71	995,416.01
19	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		185,647,770.48	186,156,050.54
20	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		185,647,770.48	186,156,050.54
21	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		15,477,803.62	14,719,029.01
22	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		30,986,374.13	35,166,493.5
23	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		1,707,344.27	1,707,344.27
24	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		129,915,698.79	127,358,288.97
25	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		7,560,549.68	7,204,894.78
26	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		193,860,079.36	195,928,587.46

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		124,736,968.58	126,855,297.49
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		33,054,937.75	36,202,914.95
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		27,181,942.18	28,607,422.79
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		27,037,536.67	28,123,155.9

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,140,007.84	-1,616,679.08
6	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар		1,284,413.35	2,100,945.97
7	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		2,348,911.94	2,907,294.58
8	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		3,524,083.62	4,688,197.58
9	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	86,512,199.24	90,652,382.54
10	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого		200,653.65	155,612.64
11	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	2,857,301.67
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,169,831.6	0.0
13	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	77,409,804.87	85,832,362.72
14	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		77,266,557.24	84,499,939.03
15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		70,931,458.56	82,155,428.27
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		22,556,751.47	26,602,704.66
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,720,073.31	3,292,003.63
18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		15,924,080.91	19,175,348.11
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		2,267,182.26	1,966,013.23
20	1.1.2.01.1.05 Нормативт зардал		1,824,480.89	428,478.3
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		904,979.63	1,489,062.77
22	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		590,553.09	654,612.75
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,653,794.39	11,006,423.75
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		15,489,562.6	17,540,781.07
25	1.1.2.01.3 ТАТААС		53,799	130,778.5
26	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,281,299.68	2,213,732.26
27	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		143,247.63	1,332,423.7
28	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		47,327,163.72	41,022,934.77
29	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		28,830,209.38	42,412,442.08
30	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-28,830,209.38	-42,412,442.08
31	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		18,496,954.34	-1,389,507.32
32	2 Засгийн газрын хувь оролцоо		0.0	700,846.9

### 2.3. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Дансны нэр, төрөл	/мянган төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	100,513,757.67	92,573,178.69
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	33,054,937.75	36,202,914.95
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	27,181,942.18	28,607,422.79
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,140,007.84	-1,616,679.08
5	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	1,284,413.35	2,100,945.97
6	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	2,348,911.94	2,907,294.58
7	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	3,524,083.62	4,688,197.58
8	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,872,510.59	2,777,292.22
9	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	665,508.39	1,009,815.56
10	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	986,064.65	901,089.81
11	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,295,429.74	56,370,263.74
12	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	18,616,046.89	14,334,698.83
13	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	256,053.65	155,612.64
14	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	2,857,301.67
15	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	43,423,329.2	39,022,650.6
16	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,163,390.18	0.0
17	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,854,664.67	77,544,382.75
18	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	70,854,664.67	77,544,382.75
19	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,508,722.19	75,194,667.15
20	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,529,362.32	29,632,497.17
21	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,383,388.19	3,265,569.77
22	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,740,096.3	17,395,694.04
23	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	2,667,206.53	2,393,386.04
24	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,558,314.87	440,048.2
25	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	1,033,159.65	1,755,858.6
26	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	584,175.49	620,533.75
27	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,472,223.62	7,839,276.1
28	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	7,540,795.23	11,851,803.48
29	1.1.1.2.01.3 ТАТААС	53,799	130,778.5
30	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,292,143.48	2,218,937.11
31	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,659,093	15,028,795.93
32	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	19,230,113.03	18,826,343.61
33	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,230,113.03	18,826,343.61
34	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	19,230,113.03	18,826,343.61
35	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-19,230,113.03	-18,826,343.61
36	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	543,000	605,887.7
37	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	136,584	0.0

38	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-679,584	-605,887.7
39	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	9,749,395.97	-4,403,435.37
40	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,641,828.24	24,391,224.21
41	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,391,224.21	19,987,788.84

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

№	Дансны нэр, төрөл	<i>/мянган төгрөгөөр/</i>		
		Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	166,357,587.33		166,357,587.33
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	224,293.55		224,293.55
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	166,581,880.88		166,581,880.88
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-183,897.55		-183,897.55
5	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	752,832.82		752,832.82
6	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	18,496,954.34		18,496,954.34
7	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,647,770.48		185,647,770.48
8	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	185,647,770.48		185,647,770.48
9	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	200,940.75		200,940.75
10	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,848,711.23		185,848,711.23
11	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-154,696.47		-154,696.47
12	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-35,843.53		-35,843.53
13	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	1,887,386.62		1,887,386.62
14	1.7 Тайлант үеийн үр дүн	-1,389,507.32		-1,389,507.32
15	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	186,156,050.54		186,156,050.54

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь “Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж үр дүнг тооцох, иргэдэд төрийн бүх талын үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх, шударга ёсыг эрхэмлэн

дээдлэх, төрийн захиргааны манлайллыг дээшлүүлэх эрхэм зорилгыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилгыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлэх;
- Төрийн хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;
- Хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах;
- Иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хөнгөн шуурхай хүргэх;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Төрийн албаны тухай хуульд - 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн сайдын тушаалаар баталсан жишиг бичиг баримт, Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн Засгийн газрын шинэчлэгдсэн [Finperform.mof.gov.mn](http://Finperform.mof.gov.mn) цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамаарах 16 сумын 30 төсөвт байгууллага, аймгийн төвийн 6 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж 48 зөрчил илрүүлснээс, 43.5 сая төгрөгийн 26 зөрчилд улсын байцаагчийн акт, 1,601.7 сая төгрөгийн 22 зөрчилд албан шаардлага өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,286.1 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,391.2	19,987.8	-4,403.4
Авлага	8,079.2	7,762.1	-317.1
Урьдчилгаа	34.9	1.0	-33.9
Бараа материал	34,255.8	14,965.3	-19,290.5
Нөөцийн бараа	264.8	7,451.6	7,186.8
Үндсэн хөрөнгө	126,834.2	145,760.9	18,926.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>193,860.1</b>	<b>195,928.6</b>	<b>2,068.5</b>
Өр төлбөр	8,212.3	9,772.5	1,560.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	185,647.8	186,156.1	508.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>193,860.1</b>	<b>195,928.6</b>	<b>2,068.5</b>

/сая төгрөгөөр/

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данснуудын тайлбарыг доор харуулав. Үүнд:

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 24,391.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 19,987.8 сая төгрөг болж 4,403.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт(-)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	5,719.1	4,377.7	-1,341.4
Төсөл/ сан	6,811.0	10,417.0	3,606.0
Төрийн сан	11,391.7	4,752.1	-6,639.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	469.4	441.0	-28.4
<b>Дүн</b>	<b>24,391.2</b>	<b>19,987.8</b>	<b>-4,403.4</b>

/сая төгрөг/

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Касс дахь мөнгөн хөрөнгийн 1.4 сая төгрөгийн үлдэгдэлд “Чандмань-Увс” ХХК-ийн үлдэгдэл 1.3 сая, “Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ -ын 0.1 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлд барьцаа хөрөнгийн 4,727.4 сая төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын 5,616.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 168.3 сая төгрөг, техник хяналтын 6.5 сая төгрөг, 19 сумын Орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн 9,002.9 сая төгрөг, бусад сан 24.8 сая, нийт 19,546.8 сая төгрөг байна.

Арилжааны 4 банкны харилцах дансанд 4 байгууллагын 439.6 сая төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг байгууллагаар нь харуулбал: Үүнд:

- “Чандмань-Увс” ХХК-ийн 6 дансанд 300.1 сая,
- “Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ-ын 4 дансанд 1.7 сая
- “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын 2 дансанд 0.04 сая,
- “Тэс сумын “Таван тэсийн илч” ОНӨААТҮГ-ын 1 дансанд 137.8 сая төгрөг тус тус байна.

**Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:**

Дараах төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд дараах залруулга хийлгэсэн.

- **Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газар:** Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 2.0 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаагүй;
- **Увс аймгийн Халамжийн сан:** Мөнгөн гүйлгээний тайланд нийт зарлагын дүнг 70.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, санхүүгийн үр дүнгийн тайланд 0.4 сая төгрөгийн орлогыг тусгаагүй;
- **Зүүнговь сумын Засаг даргын Тамгын газар:** Үр дүнгийн тайланд цалин болон нэмэгдэл урамшууллын 6.9 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9.1 сая, хангамж бараа материалын зардлыг 3.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 29.7 сая төгрөгөөр дутуу, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 6.9 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн.

**3.4.2 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 8,079.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,762.1 сая төгрөг болж 317.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 3 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт (±) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	17.7	43.5	25.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	0.0	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	0.0
Зээлийн хүүгийн авлага	138.9	108.0	-30.9
Дансны авлага /ТӨҮГ/	268.7	84.4	-184.3
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.6	11.9	11.3
Бусад авлага	4,126.3	4,319.2	192.9
Зээлийн авлага	3,527.0	3,195.1	-332.1
<b>Дүн</b>	<b>8,079.2</b>	<b>7,762.1</b>	<b>-317.1</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	4,278.5	3,794.8	-483.7

Төсөл/ сан	2,137.7	2,424.3	286.6
Төрийн сан	1,201.2	1,201.2	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	461.8	341.8	-120.0
<b>Дүн</b>	<b>8,079.2</b>	<b>7,762.1</b>	<b>-317.1</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Нийт авлагын өсөлтөд ажиллагсадтай холбогдсон авлага 25.8 сая төгрөг, татвар, НДШ-ийн авлага 11.3 сая төгрөг, бусад авлага 410.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлж байна. Харин 30.9 сая төгрөгийн зээлийн хүүгийн авлага, 184.3 сая төгрөгийн дансны авлага, 332.1 сая төгрөгийн зээлийн авлага буурсан байна.

Авлагын үлдэгдлийн 3,365.1 сая төгрөг буюу 42.2 хувь нь Хоршоо хөгжүүлэх сангийн дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага, 288.3 сая буюу 3.6 хувь нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага, 345.8 сая төгрөг буюу 4.3 хувь нь төсөвт байгууллагын авлага, 341.8 сая төгрөг буюу 4.2 хувь нь Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн авлага, 2,037.7 сая төгрөг буюу 28.3 хувь нь зураг, төсвийн авлага, 1,201.2 сая буюу 15 хувь нь аймгийн Орон нутгийн ерөнхий орлого дансны авлага голлох хувийг эзэлж байна. Мөн Барьцаа дансны авлага 70.9 сая, Байгаль хамгаалах сангийн дансны авлага 13.2 сая, Гамшгаас хамгаалах сангийн 98.1 сая төгрөгийн авлага тус тус байна.

Авлагын дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай 79.1 сая төгрөгийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн авлага байна. Үүнд: Аймгийн төсвөөс аж ахуйн нэгж, байгууллагуудад олгосон үр тарианы болон бусад зориулалттай зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 53.0 сая төгрөгийн авлага байна. Мөн шүүхийн шийдвэр гарсан хоршооны барагдаагүй байгаа 26.1 сая төгрөгийн авлага байна.

#### **Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:**

Дараах төсвийн шууд захирагчид 2025 оны санхүүгийн тайланд авлага, орлогыг буруу илэрхийлснийг залруулга хийлгэсэн.

- **Өндөрхангай сумын Засаг даргын Тамгын газар:** Албан хаагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын тайланд тайлагнахдаа даатгуулагчийн кодыг буруу сонгон тайлагнаж, 0.7 сая төгрөгийг илүү шилжүүлснийг санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй;
- **Давст сумын Засаг даргын Тамгын газар:** Авлагын дансанд 0.4 сая төгрөгийн авлагыг илүү тусгасан;
- **Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Тайлант оны 8 дугаар сард нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг бодохдоо иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг 1.0 сая төгрөгөөр илүү тайлагнаж, 0.2 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй.

#### **3.4.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 34.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1.0 сая төгрөг болж 33.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	---------------------------

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Урьдчилж гарсан зардал	34.9	1.0	-33.9
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0	0.0
Цалингийн урьдчилгаа	0.0	0.0	0.0
Томилолтын урьдчилгаа	0.0	0.0	0.0
<b>Дүн</b>	<b>34.9</b>	<b>1.0</b>	<b>-33.9</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	0.0	0.0	0.0
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	34.9	1.0	-33.9
<b>Дүн</b>	<b>34.9</b>	<b>1.0</b>	<b>-33.9</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Тайлант оны эцэст урьдчилгаа дансанд “Чандмань-Увс” ХХК-ийн урьдчилж гарсан зардлын 1.0 сая төгрөгийн үлдэгдэл байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 34,255.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14,965.3 сая төгрөг болж 19,290.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 5 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Түүхий эд материал	538.8	235.2	-303.6
Хангамжийн материал	33,139.1	14,142.0	-18,997.1
Биологийн хөрөнгө	43.7	47.1	3.4
Мал амьтад	534.2	541.0	6.8
<b>Дүн</b>	<b>34,255.8</b>	<b>14,965.3</b>	<b>-19,290.5</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	33,469.2	14,373.3	-19,095.9
Төсөл/ сан	0.0	82.0	82.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	786.6	510.0	-276.6
<b>Дүн</b>	<b>34,255.8</b>	<b>14,965.3</b>	<b>-19,290.5</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Бараа материал 19,290.5 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

**Нийт нэмэгдсэн бараа материал 266,878.2 сая төгрөг:**

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 265,501.5 сая,
- Хандиваар авсан 149.4 сая,
- Шилжүүлэн авсан 112.9 сая,
- Бусад эх үүсвэрээр авсан 1,114.4 сая төгрөг

**Нийт хасагдсан бараа материал 249,013.6 сая төгрөг:**

- Тайлант хугацаанд зарцуулсан 240,770.3 сая,
- Шилжүүлсэн 11.9 сая,
- Бусад 8,231.4 сая төгрөг

**Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:**

Дараах төсвийн шууд захирагчид 2025 оны санхүүгийн тайланг буруу илэрхийлснийг залруулга хийлгэсэн.

- **Сумдын Засаг даргын Тамгын газар:** Бараа материалын тайлангийн мал амьтад дансанд бүртгэлтэй Герефорд үйлдвэрийн бухыг нас дэвшүүлээгүй байсан. Үүнд:

- Зүүнговь сумын Засаг даргын Тамгын газар нь 11.9 сая төгрөгийн 3 бух;
- Өндөрхангай сумын Засаг даргын Тамгын газар нь 11.9 сая төгрөгийн 3 бух;
- Давст сумын Засаг даргын Тамгын газар нь 11.9 сая төгрөгийн 3 бух;
- Хяргас сумын Засаг даргын Тамгын газар нь 7.9 сая төгрөгийн 2 бух;
- Цагаанхайрхан сумын Засаг даргын Тамгын газар нь 3.9 сая төгрөгийн 1 бух;
- Зүүнхангай сумын Засаг даргын Тамгын газар нь Геррефорд үүлдрийн 3.8 сая төгрөгийн 1 бухан бяруу, Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлсэн 3.9 сая төгрөгийн 1 бух;
- **Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс бэлтгэсэн 34.0 сая төгрөгийн өвсийг сумын Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сангийн бараа материалын дансанд давхардуулан бүртгэсэн;
- **Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Сумын 2025 оны төсөв батлах тухай 19 дүгээр тогтоолоор батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Малын үүлдэр угсааг сайжруулах” төсөл, арга хэмжээний хүрээнд 4.0 сая төгрөгөөр 40 ширхэг хурган хуц худалдан авсныг орлогод аваагүй;
- **Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Санхүүгийн нэгтгэл тайлангийн бараа материалын тодруулгад Засаг даргын тамгын газрын худалдан авсан сэлбэг хэрэгсэл 9.5 сая, түлш, шатах тослох материал 44.5 сая, нийт 54.0 сая төгрөгийн материалыг хандиваар авсан бараа материалаар бүртгэсэн;
- **Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдаж авсан 70.0 сая төгрөгийн өвс, тэжээлийг бараа материалын дансанд бүртгээгүй байсан.

### 3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 11,482.7 сая төгрөгийн дуусаагүй барилгаас 4,468.5 сая төгрөгийг ашиглагч байгууллагад шилжүүлж, үлдэгдэл 7,014.2 сая төгрөгийн дуусаагүй барилга бүртгэлтэй байна.

Нөөцийн бараа материалын эхний үлдэгдэл 264.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 437.4 сая төгрөг болж 172.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 6 Нөөцийн бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	53.5	59.0	5.5
Тэжээлийн нөөц	211.3	378.4	167.1
<b>Нөөцийн бараа</b>	<b>264.8</b>	<b>437.4</b>	<b>172.6</b>
<b>Дүн</b>			
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	53.5	226.1	172.6
Төсөл/ сан	211.3	211.3	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.0	0.0	0.0

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Нөөцийн бараа 172.6 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

**Нийт нэмэгдсэн бараа материал 10,843.1 сая төгрөг:**

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 10,677.9 сая,
- Хандиваар авсан 30.0 сая,
- Бусад эх үүсвэрээр авсан 135.2 сая төгрөг

**Нийт хасагдсан бараа материал 10,670.5 сая төгрөг:**

- Тайлант хугацаанд зарцуулсан 25.7 сая,
- Бусад 10,644.8 сая төгрөг

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 126,834.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 145,760.9 сая төгрөг болж 18,926.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	66,358.6	72,299.7	5,941.1
Хуримтлагдсан элэгдэл	-14,071.8	-16,046.1	-1,974.3
Авто тээврийн хэрэгсэл	11,037.9	13,100.2	2,062.3
Хуримтлагдсан элэгдэл	-4,925.5	-5,652.0	-726.5
Машин тоног төхөөрөмж	18,161.3	20,953.0	2,791.7
Хуримтлагдсан элэгдэл	-8,128.1	-9,289.3	-1,161.2
Тавилга, эд хогшил	3,264.2	3,833.6	569.4
Хуримтлагдсан элэгдэл	-1,991.1	-2,107.3	-116.2
Зам, гүүрний байгууламж	46,608.1	25,213.2	-21,394.9
Хуримтлагдсан элэгдэл	-15,638.7	-4,149.8	11,488.9
Түүх соёлын дурсгалт зүйлс	10.2	10.2	0.0
Бусад үндсэн хөрөнгө	20,406.3	49,201.5	28,795.2
Хуримтлагдсан элэгдэл	-5,123.2	-12,725.3	-7,602.1
Дуусаагүй барилга, байгууламж	289.6	646.7	357.1
Ном	128.1	128.1	0.0
Программ хангамж	141	241.5	100.5
Хуримтлагдсан элэгдэл	-119.9	-134.7	-14.8
Бусад биет бус хөрөнгө	10,710.7	10,627.9	-82.8
Хуримтлагдсан элэгдэл	-283.5	-390.2	-106.7
<b>Дүн</b>	<b>126,834.20</b>	<b>145,760.90</b>	<b>18,926.7</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	108,117.8	104,593.6	-3,524.2
Төсөл/ сан	2.9	2.9	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	18,713.5	41,164.4	22,450.9
<b>Дүн</b>	<b>126,834.2</b>	<b>145,760.9</b>	<b>18,926.7</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Тайлант онд үндсэн хөрөнгө данс нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,950.1 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 4,014.1 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 663.4 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 0.5 сая, бусад эх үүсвэрээр авсан 36,477.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, худалдсан 146.2 сая, балансаас балансад шилжүүлсэн 19,494.9 сая, акталсан хөрөнгө 5,321.2 сая, бусад 4.1 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга, байгууламжийн үлдэгдэл 646.7 сая төгрөг байгаа нь Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ, Давст, Малчин, Наранбулаг, Өмнөговь, Түргэн, Улаангом сумдын Засаг даргын тамгын газрын дансанд хийгдэж дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлууд бүртгэлтэй байна.

### Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

Дараах төсвийн шууд захирагчид 2025 оны санхүүгийн тайланг буруу илэрхийлснийг залруулга хийлгэсэн.

- **Малчин сумын Засаг даргын Тамгын газар:** Орон нутгийн өмчийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр данснаас хасах хөрөнгийн жагсаалтад оруулсан Малчин сумын Засаг даргын тамгын газрын данс бүртгэлд байсан Багийн төвийн конторын барилга 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй;
- **Түргэн сумын Засаг даргын Тамгын газар:** Засаг даргын нөөц хөрөнгөнөөс авсан 2.3 сая төгрөгийн цахилгааны нөөц үүсгэврийг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй;
- **Зүүнхангай сумын Засаг даргын Тамгын газар:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 69 дүгээр тогтоолын дагуу үнэ төлбөргүй шилжин ирсэн 200.0 сая төгрөгийн өртөгтэй “Увс 100” цогцолбор хөшөөг бүртгэлд тусгаагүй;
- **Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Санхүүгийн нэгтгэл тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулгад Засаг даргын тамгын газрын бусад эх үүсвэрээр авсан тавилга хэрэгсэл 7.1 сая төгрөгийн худалдан авсан хөрөнгөд бүртгэсэн;

**Шинэ Улаангом ОНӨААТҮГ:** Шинэ Улаангом ОНӨААТҮГ нь 2,388.6 сая төгрөгийн анхны өртөгтэй Худалдааны төвийн барилга 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр шатсантай холбогдуулан эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гараагүй тул үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулаагүй байсанд зөвлөмж өгсөн.

### 3.4.7 Өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 8,212.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,772.6 сая төгрөг болж, 1,560.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)
Өглөг	7,111.4	8,744.5	1,633.1
Урьдчилж орсон орлого	22.2	32.7	10.5
Урт хугацаат зээл	1,078.7	995.4	-83.3
<b>Нийт дүн</b>	<b>8,212.3</b>	<b>9,772.6</b>	<b>1,560.3</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	320.8	3,019.2	2,698.4
Төсөл, сан	6,375.4	5,402.5	-972.9
Төрийн сан	3.1	3.1	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,513.0	1,347.8	-165.2
<b>ДҮН</b>	<b>8,212.3</b>	<b>9,772.6</b>	<b>1,560.3</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Нийт өр төлбөрийн данс нь 1,560.3 сая төгрөгөөр өсөхөд төсөвт байгууллагын өглөг голлох нөлөөг үзүүлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 995.4 сая төгрөг болж 83.3 сая төгрөгөөр буурсан нь “Шинэ Улаангом” ОНӨААТҮГ-ын 83.3 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг төлсөнтэй холбоотой байна.

### Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

Дараах төсвийн шууд захирагчид 2025 оны санхүүгийн тайланг буруу илэрхийлснийг залруулга хийлгэсэн.

- **Давст сумын Засаг даргын Тамгын газар:** Өглөгийн дансанд 1.7 сая төгрөгийг дутуу тусгасан;

- **Сагил сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Нэг албан хаагчаас 0.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү суутган тооцсоныг өглөгөөр бүртгээгүй;
- **Бөхмөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Нэг албан хаагчид 0.2 сая төгрөгийн цалинг дутуу олгосныг өглөгөөр тусгаагүй;
- **Өмнөговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарын 9, 11, 12 дугаар сарын олгоогүй 7.3 сая төгрөгийн урамшууллыг санхүүгийн тайландаа тусгаагүй;
- **Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль:** 2023 оны төсвийн жилийн дундуур үнэ тарифын нэмэгдэлтэй холбоотойгоор үүссэн түлш, халаалтын өр төлбөрийг тайлант онд Шүүхийн шийдвэрийн дагуу 46.8 сая, 2025 оны түлш халаалтын өр төлбөрөөс 14.0 сая, нийт 60.8 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нэгдсэн данснаас төлснийг үр дүнгийн тайланд тусгаагүй;
- **Наранбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль:** Түлш халаалтын 27.5 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй;
- **Аймгийн Засаг даргын Тамгын газар:** Санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдлийг 2.3 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байсан.

### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 185,647.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 186,156.0 сая төгрөг болж 508.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 9 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), бууралт(-)
Засгийн газрын оруулсан капитал	15,050.9	14,719.0	-331.9
Өмч /Төрийн/ ТӨҮГ	31,413.3	35,166.5	3,753.2
Эздийн өмчийн бусад хэсэг ТӨҮГ	1,707.3	1,707.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	129,915.7	127,358.3	-2,557.4
Өмнөх үеийн үр дүн	111,418.7	128,747.8	17,329.1
Тайлант үеийн үр дүн	18,497.0	-1,389.5	-19,886.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,560.6	7,204.9	-355.7
<b>Дүн</b>	<b>185,647.8</b>	<b>186,156.0</b>	<b>508.2</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	151,307.6	131,565.5	-19,742.1
Төсөл, сан, бусад	2,787.5	2,128.2	-659.3
Төрийн сан	12,589.8	11,397.5	-1,192.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	18,962.9	41,064.8	22,101.9
<b>Дүн</b>	<b>185,647.8</b>	<b>186,156.0</b>	<b>508.2</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Өмчийн дансны үлдэгдэл 35,166.5 сая төгрөг болж 3,753.2 сая төгрөгөөр өсөхөд Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Сагил, Хяргас сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Чандмань-Увс ХХК-ийн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан үр дүн 127,358.3 сая төгрөг болж 2,557.4 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх үеийн үр дүн 129,915.7 сая төгрөгөөс 128,747.8 сая төгрөг болж 1,167.9 сая төгрөгөөр буурсан нь Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэйгээс бусад хөрөнгийг /1,353.0 сая төгрөг/ бүртгэлээс хассан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 7,204.9 сая төгрөг болж 355.7 сая төгрөгөөр буурсан нь дахин үнэлгээтэй хөрөнгийг бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

### 3.4.9 Орлогын данс

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 105,196.5 сая төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Хүснэгт № 10. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/
			зөрүү
Татварын орлого	33,054.9	36,202.9	3,148.0
Татварын бус орлого	4,417.3	3,755.7	-661.6
Хөрөнгийн орлого	256.1	155.6	-100.5
Тусламж, санхүүжилтийн орлого	43,423.3	65,082.3	21,659.0
<b>Нийт дүн</b>	<b>81,151.6</b>	<b>105,196.5</b>	<b>24,044.9</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Нийт орлогын дүн 105,196.5 сая төгрөг болж өмнөх оноос 24,044.9 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.4.10 Зардлын данс

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийт 108,127.4 сая төгрөгийн зардлыг тайлагнасан байна.

Хүснэгт № 11. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/
			зөрүү
Бараа ажил үйлчилгээний зардал	53,594.0	61,331.9	7,737.9
Татаас	53.8	130.8	77.0
Урсгал шилжүүлэг	2,259.2	27,938.9	25,679.7
Хөрөнгийн зардал	18,562.4	18,725.8	163.4
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>74,469.4</b>	<b>108,127.4</b>	<b>33,658.0</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Нийт зардлын дүн 108,127.4 сая төгрөг болж өмнөх оноос 33,658.0 сая төгрөгөөр өссөн байна.

#### Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- **Байгаль орчны газар:** Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн цалингийн зардлыг 0.2 сая төгрөгөөр дутуу, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.2 сая төгрөгөөр илүү илэрхийлсэнд залруулга хийлгэсэн;
- **Бөхмөрөн сумын Засаг даргын Тамгын газар:** Төрийн сангийн мэргэжилтний ажил үүрэгт хамааралгүй ажлын үр дүнг үнэлж Бөхмөрөн сумын засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар санхүүгийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэж 1.4 сая төгрөгийн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон;
- **Сагил сумын Засаг даргын Тамгын газар:** Бараа үйлчилгээний бусад зардал, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас Сагил сумын Засаг даргын 2025 оны А/04 дүгээр захирамжаар 2.0 сая, Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар 5.0 сая нийт 7.0 сая төгрөгийг бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарцуулсанд албан шаардлага өгсөн;

- **Наранбулаг сумын Засаг даргын Тамгын газар:** Наранбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.2-д “түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүйд албан шаардлага өгсөн.
- **Наранбулаг сумын Засаг даргын Тамгын газар:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.” гэж заасан байхад 12.1 сая төгрөгийн гүйлгээг шууд зардалд бүртгэсэнд залруулга хийлгэсэн;
- **Өлгий сумын Засаг даргын Тамгын газар:** Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 239.4 сая төгрөгийг илүү тайлагнасанд залруулга хийлгэсэн;
- **Завхан сумын Засаг даргын Тамгын газар:** Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 0.7 сая төгрөгийн 2 гүйлгээг хийсэнд зөвлөмж өгсөн;
- **Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газар:** Батлагдсан бүтцэд байхгүй хогны асуудал хариуцсан мэргэжилтэн, олон нийтийн цагдаа гэсэн орон тоонд ажилтан томилж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан тайлант онд нийт 5.6 сая төгрөгийн цалин хөлс олгосонд зөвлөмж өгсөн;
- **Улаангом сумын Засаг даргын Тамгын газар:** Улаангом сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс иргэнд үзүүлсэн дэмжлэгийг Улаангом сумын Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас давхардуулан 1.5 сая төгрөг шилжүүлсэнд төлбөрийн акт тогтоосон;
- **Түргэн сумын Засаг даргын Тамгын газар:**
  - Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төсвөөс “Арвиншүтээн” ХХК-д 10.0 сая төгрөгийг шилжүүлэн авч зарцуулахдаа 0.5 сая төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт гэж суутгуулсан, 0.7 сая төгрөгөөр архи согтууруулах ундаа худалдаж авсанд төлбөрийн акт тогтоосон;
  - Засаг даргын нөөц хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар хурлын төлөөлөгч нарт дэвтэр бал, хавтасны зардалд 1.1 сая төгрөгийн зардал гаргасанд зөвлөмж өгсөн;
- **Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Байгууллагын батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй нярвын ажлыг хавсруулж 5.1 сая төгрөгийн нэмэгдэл цалин олгосонд зөвлөмж өгсөн;
- **Тариалан сумын Засаг даргын Тамгын газар:** Мал тооллогын урамшууллын зардлаас 0.9 сая, 2025 оны 07 дугаар сарын цалингаас 1 ажилтны 0.7 сая, нийт 1.6 сая төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгасан боловч, тайланд тусгаагүйд зөвлөмж өгсөн;
- **Улаангом сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Улаангом сум нь 2024 онд шилдэг сумаар шалгарч хурлын дарга болон ажлын албаны даргад мөнгөн урамшуулал олгохдоо 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн Б/09 дүгээр тушаал, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Б/23 дугаар тушаалаар ИТХ-ын 2 албан хаагчид 1.9 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосонд зөвлөмж өгсөн;
- **Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан:**
  - Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг урьд оны дансны үлдэгдэл 1,244.7 сая төгрөг байхад 1,313.6 сая төгрөг буюу 68.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулсанд зөвлөмж өгсөн;
  - Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр баталсан “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлд оруулах тухай”

хуулийн 17 дугаар зүйлд “2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна. Үүнд: 15. Увс 10,770.9 сая төгрөг” гэж баталсан байхад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолын 6-д Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 10,780.9 сая төгрөгөөр баталсанд зөвлөмж өгсөн;

- **Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Халуун усны байр засварлах болон тохижуулах 19.0 сая төгрөгийн өртөгтэй ажилд 13.3 сая, Хүрэн морьтын давааны хөтлийн тохижилт 19.5 төгрөгийн өртөгтэй ажилд 16.6 сая, Ногоон байгууламжийн хашаа засварлах 3.0 сая төгрөгийн өртөгтэй ажилд 2.1 сая, нийт 9.4 сая төгрөгөөр дутуу буюу урьдчилгаа төлбөрийн дүнгээр нь гэрээ байгуулсанд зөвлөмж өгсөн;
- **Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:**
  - Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор Малын ангилан ялгалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 5.0 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 5.6 сая төгрөг буюу 0.6 сая төгрөг илүү зарцуулсанд зөвлөмж өгсөн;
  - Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор батлагдсан ажлын жагсаалтад байхгүй Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын санхүүжилтэд 13.0 сая төгрөгийг өмнөх онд иргэдэд зээлээр борлуулсан өвсний үнийн эргэн төлөлтөөс шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэнд зөвлөмж өгсөн;
- **Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Түргэн сумын Засаг дарга нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/78 дугаар захирамжаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 06/01 дугаар тогтоолоор баталсан “Дэлгэрмөрөн самбартай хөтөлд үдэлт, угталтын талбайн засвар” төсөл, арга хэмжээнд 5.0 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өгсөн;
- **Увс аймгийн Чандмань-Увс ХХК:**
  - 2025 онд 16 ажилтанд олгосон 23.8 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант хугацаанд суутган тооцоогүйд зөвлөмж өгсөн;
  - Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар нэг албан хаагчид ногдуулсан сахилгын шийтгэлийн 0.8 сая төгрөгийг суутган тооцоогүйд төлбөрийн акт тогтоосон;
- **Дун цагаан нөхөрлөл ББН:** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 хавсралтад орон нутгийн нэмэгдлийг 20%-аар олгохоор заасан байхад нөхөрлөлийн гишүүдийн 1 дүгээр хурлын шийдвэрээр 7 эмчид 20%-аар бусад ажилтнуудад 15%-аар тооцож олгосонд зөвлөмж өгсөн;
- **Элбэг-Өгөөж ББН:** Элбэг-Өгөөж өрхийн эмнэлгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар нягтлан бодогчид 2 сарын үндсэн цалинтай тэмцэх хэмжээний буюу 2.2 сая төгрөгийн урамшуулал цалин олгож Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.3 дахь хэсэгт “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байна” гэж зааснаас 0.5 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосонд зөвлөмж өгсөн;
- **Мөнхбишрэлт ББН:**
  - Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 хавсралтын 3.3-д заасан хэмжээнээс илүү 0.6 сая төгрөгийн урамшууллыг Мөнхбишрэлт өрхийн эрүүл

мэндийн төвийн даргын Б/09 дүгээр тушаалаар нягтлан бодогчид олгосонд зөвлөмж өгсөн;

- Ажилтнуудад орон нутгийн нэмэгдлийг олгоходоо 1 ажилтанд 10 хувь, 12 ажилтанд 15 хувь, 6 ажилтанд 20 хувиар тооцож ялгавартай олгосонд зөвлөмж өгсөн;
- Мөнхбишрэлт ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 тушаалаар 20 орон тоотой байхаар баталж, гүйцэтгэлээр 19 орон тоотой ажилласан байхад батлагдсан бүтэц орон тоонд байхгүй 5 ажлын байрыг хавсран ажиллуулахаар тусгаж хавсран ажилласны нэмэгдлийг 30-40 хувиар тооцон олгосонд зөвлөмж өгсөн;
- **Бат-Үржихүй нөхөрлөл ББН:**
  - Тээвэр шатахууны 1.0 сая төгрөгийн зардлыг мөнгөн гүйлгээний тайланд түлш, халаалтын зардалд, 1.3 сая төгрөгийн орон нутгийн төсөвт байгууллагын санхүүжилтийг мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайланд эрүүл мэндийн даатгалын санхүүжилт рүү тайлагнасанд залруулга хийлгэсэн;
  - Бат-Үржихүй өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны Б/09 дүгээр тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэж заасныг үндэслэн Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3-д “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухай ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэж заасныг зөрчин Бат-Үржихүй өрхийн эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчид 0.7 сая төгрөгийн мөнгөн урамшуулал илүү олгосонд зөвлөмж өгсөн;
- **Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ:**
  - “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын менежер албан тушаалтай ажилтанд сахилгын шийтгэлтэй байх хугацаанд 0.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон;
  - Үр дүнгийн тайлангаар 12.8 сая төгрөгийн ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн зардалд бүртгэснийг залруулга хийлгэсэн.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Увс аймгийн 2025 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор 128,646.7 сая төгрөгөөр анх баталж, Увс аймгийн 2025 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар тогтоолоор зохицуулалт хийж төсвийн орлогыг 370.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор 115,365.7 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 115,365.7 сая төгрөгийн төсөв баталснаас 10,770.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 91,617.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 12,977.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 10,680.6 сая, орон нутгийн төсвөөс 95,655.2 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,791.6 сая, нийт 108,127.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч 2025 онд 25 хөтөлбөрийг санхүүжүүлэхэд 108,127.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөрийн нэр	/сая төгрөг/		
		Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	6,103.2	5,696.1	407.0
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	72,733.6	69,034.6	3,699.0
3	Худалдан авах ажиллагаа	482.5	464.4	18.1
4	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	513.1	467.1	46.1
5	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	494.1	475.6	18.5
6	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	10,907.3	10,907.3	-
7	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	600.0	573.2	26.8
8	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	245.5	192.5	53.0
9	Мал аж ахуйг хөгжүүлэх	1,055.9	1,055.9	-
10	Авто зам	1,188.9	1,159.2	29.7
11	Ойжуулалт	438.9	404.9	34.0
12	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2,081.5	2,068.6	12.9
13	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	597.6	437.1	160.5
14	Хот байгуулалт, тохижилт	-	-	-
15	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	2,419.5	2,345.6	73.9
16	Биеийн тамир спорт	674.3	674.3	0.0
17	Соёл урлаг	1,842.9	1,466.4	376.5
18	Сургуулийн өмнөх боловсрол	2,181.6	2,083.5	98.1
19	Ерөнхий боловсрол	6,791.1	6,687.0	104.1
20	Мэргэжлийн боловсрол	662.0	661.8	0.1
21	Нийгмийн халамж	491.4	330.5	160.9
22	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,574.3	661.4	1,912.9
23	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	40.6	40.6	-
24	Ахмад настны хөгжил хамгаалал	115.2	109.2	6.1
25	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	130.6	130.6	-
<b>Нийт дүн</b>		<b>115,365.7</b>	<b>108,127.4</b>	<b>7,238.3</b>

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.6.10 дахь заалтад “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь” гэж заасны дагуу 2025 онд Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 2,186.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,100.9 сая төгрөг бүрдүүлж орлогын төлөвлөгөө 85.0 сая төгрөгөөр тасарсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд хандив, тусламж 100.8 сая, Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-өөс 6,079.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1,099.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 376.9 сая, нийт 7,656.2 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс урсгал зардалд 5,313.9 сая, хөрөнгийн зардалд 1,498.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын ерөнхий чиглэлийн судалгааг нэгтгэн хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 13. Ерөнхий чиглэлийн судалгаа

Сая төг/

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл /орон тоо/	Тайлбар
1	Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын судалгаа	1,737.4	1,715.0	ТЕЗ-ийн харьяаны 56 байгууллагаас 14 байгууллага 2025 онд 1,715.0 сая төгрөгийг унаа, хоолны зардалд зарцуулсан байна.
2	Гадаад томилолт, арга хэмжээний зардал	30.2	117.6	ТЕЗ-ийн харьяаны 4 байгууллага 2025 онд гадаад томилолтын зардалд 5 арга хэмжээ төлөвлөж төсөв баталсан боловч гүйцэтгэлээр 21 арга хэмжээнд 117.6 сая төгрөгийг гадаад томилолтын зардал зарцуулсан байна.
3	Төрд учирсан хохирол барагдуулах зардал	104.3	91.7	ТЕЗ-ийн харьяаны 7 байгууллагын төрд учирсан хохирлын 104.3 сая төгрөгөөс тухайн онд 91.7 саяыг барагдуулж, 14.4 саяыг авлагаар бүртгэсэн байна.
4	Программ хангамжийн бүртгэл		246.3	ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын санхүү бүртгэлд 246.3 сая төгрөгийн программ хангамж бүртгэлтэй байна.
5	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал	707.2	446.7	ТЕЗ-ийн харьяаны 26 байгууллага 707.2 сая төгрөгийг сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардалд зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 446.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийт зардлын 31.6 хувийг эрх бүхий этгээдээс баталсан тушаал, шийдвэргүйгээр зарцуулсан байна.
6	Байгууллагуудын орон тооны цомхотголын судалгаа	1,118	1,095	ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын тодотгосон орон тоог 1,118 байхаар баталснаас 1,095 орон тоо ажиллаж 15 орон тоо дутуу ажиллаж, 8 хүн цомхотгосон байна.
7	Хэвлэл, мэдээллийн зардал	151.4	148.1	ТЕЗ-ийн харьяаны 28 байгууллага 2025 онд 151.4 сая төгрөгийн хэвлэл, мэдээллийн зардалд зарцуулахаар төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 148.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгаа

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймагт тайлант онд дараах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 13. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	2025 онд зарцуулсан төсөв	Нийт зарцуулсан
1	Төв цэвэрлэх байгууламжийн гадна цахилгаан хангамж /Польш улсын нөхцөлт зээл/	2023-2026	Цэвэрлэх байгууламжийн бусад барилга байгууламжийг барих нөхцөл бүрдэх.	Польш Улсаас олгосон нөхцөлт зээлийн 12,813.7 сая төгрөгийн хөрөнгөөр, "Хатанбаатар" ХХК-ийн зураг төслөөр, ерөнхий гүйцэтгэгч "Смарт вейст технологджис" ХХК, туслан гүйцэтгэгч "Сан" ХХК болон "Их делта инженеринг" ХХК-иуд хамтран 3000 м3/хоногийн хүчин чадалтай "Увс аймгийн бохир ус цэвэршүүлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих" ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Улсын комисс ажиллаж, үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авсан. 2025 оны санхүүжилт 4,056.5 сая төгрөг болно.	4,056.5 сая төгрөг	2023 онд 759,772 евро, 2024 онд 1,888,520 евро 2025 онд 1,150,567.97 евро,
2	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл	2020-2027	Сонгож авсан тусгай хамгаалалттай газар нутгууд болон холбоос нутгуудын (орчны бүс болон экологийн коридор, манайд бол кластер) тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, нутгийн ард иргэдийн амьжиргааг дэмжих зорилготой	Ханхөхийн нуруу, Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Увс нуур Тэс голын сав газрын захиргаа, Ачит нуур Дэвэлийн байгалийн цогцолборт газрын захиргаанд тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг буцалтгүй тусламжаар өгсөн.	342.0 сая төгрөг	2024 онд 878.5 /сая.төг/ 2025 онд 342.0 /сая.төг/
3	Азийн хөгжлийн банк "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл	2020-2025	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар,	Үндсэн барилгын ажил дууссан Улсын комисс 2026 оны 2 сард ажилласан.	11.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж	Нийт 4.8 сая доллар

мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөл		хүртээмж сайжирна.			
--	--	--------------------	--	--	--

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох, аудитор Т.Золоо, Т.Ариунсайхан, Б.Нямбуу нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 8/516 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд суурь үзүүлэлтийг 2025 оны санхүүгийн тайлан гарах цаглаварт хугацаа болоогүй байгаа тул 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 776.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 85,832.4 сая төгрөгийн 1 хувиар буюу 858.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 686.7 сая төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг төсвийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар хэрэгжүүлж ажиллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 133.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 7.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 112.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах 13 албан шаардлага, 13.2 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн байна.

#### **Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:**

Дараах төсвийн шууд захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсанд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгсөн.

- **Завхан сумын Засаг даргын Тамгын газар:** Төсвийн хөрөнгөөр 1.3 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан;
- **Бөхмөрөн сумын Засаг даргын Тамгын газар:** Засаг даргын нөөц хөрөнгөөс Бөхмөрөн сумын Засаг даргын 2025 оны А/177 дугаар захирамжаар Улаанбаатар хотын нутгийн зөвлөлийн дарга, тэргүүлэгчдэд бэлгийн багц худалдан авахад төсвөөс 0.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- **Сагил сумын Засаг даргын Тамгын газар:** Бараа үйлчилгээний бусад зардлаас Сагил сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар Хөвсгөл, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалтад зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 1.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- **Малчин сумын Засаг даргын Тамгын газар:** Сумын Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Арван баядын ноён уул болох Баянхайрхан уулын овооны тахилга зохион байгуулахад 3.3 сая, А/148 дугаар захирамжаар Улаанбаатар, Дархан хотын нутгийн зөвлөлтэй хамтран сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх арга хэмжээний үйл ажиллагааны зардалд 1.0 сая, А/105 дугаар захирамжаар Эх, үрсийн баярын арга хэмжээнд 1, 2 дугаар одон авсан эхчүүд болон уран, дархан бэр шагнаж урамшуулах бэлэг дурсгалын зүйл авахад 2.0 сая, нийт 6.3 сая төгрөгийг зарцуулсан;
- **Аймгийн Засаг даргын Тамгын газар:** Бараа үйлчилгээний бусад зардал, мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас аймгийн 100 жилийн ойн үйл ажиллагаанд зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 28.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- **Улаангом сумын Засаг даргын Тамгын газар:** Төсвийн хөрөнгөөр 30.3 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан;
- **Түргэн сумын Засаг даргын Тамгын газар:** Засаг даргын нөөц хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 3.5 сая төгрөгийг бэлэг дурсгал, хоол, унаа, байрны зардалд, А/52 дугаар захирамжаар Махардгийн овоо тахихад 3.2 сая, А/24 дүгээр тушаалаар

Засаг даргын тамгын газрын албан хаагчид Түргэн сумаас ОХУ-ын Абакан хот руу явсан тээврийн хөлс 5.0 сая, нийт 11.7 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан;

- **Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаалаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтад суух, туршлага судлах ажлаар явахад ирж, очих унааны зардал гэж 4.0 сая төгрөгийг аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан авч бензин, чойжин ламын музей үзэх, бэлэг дурсгал, сургалтын төлбөр зэрэгт төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан;
- **Увс аймгийн Чандмань-Увс ХХК:** “Чандмань-Увс” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/07, А/11, А/17, А/44 дүгээр тушаалуудаар тэмцээн уралдаан болон ажилчдын хүүхдүүдэд шинэ жилээр бэлэг өгөхөд компанийн төсвөөс 6.2 сая төгрөгийг зарцуулсан.

Дараах төсвийн шууд захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн хөрөнгөөр тэмцээн, уралдаан зохион байгуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгсөн.

- **Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар захирамжаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Үндсэн хуулийн өдөрт зориулсан бөхийн барилдааны шагналын зардалд 0.5 сая, 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 18 дугаар захирамжаар “Марш тактик”-ын тэмцээн зохион байгуулахад 0.5 сая, нийт 1.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- **Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ:** “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын захирлын 2025 оны А/04, А/30, А/39 дүгээр тушаалуудаар баруун бүсийн нөхөрсөг уулзалт, спортын уралдаан, тэмцээнүүдэд болон нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын ажилчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд төсвөөс 9.6 сая төгрөгийг зарцуулсан;
- **Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Өмнөговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс тэмцээн уралдаан, баярын зардалд 6.9 сая төгрөгийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан санхүүжүүлсэн.

**Бөхмөрөн сумын Засаг даргын Тамгын газар:** “Хөх тэнгэрийн эсгий туургатан” НҮТББ-д сумын түүх, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай нэвтрүүлэг хийхэд зориулж Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/13 тушаалаар 3.0 сая, А/15 дугаар тушаалаар 1.0 сая, МБСТВ ХХК-д 2025 оны А/06 дугаар тушаалаар 1.5 сая, нийт 5.5 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өгсөн.

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Бараа үйлчилгээний бусад зардлаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албан хаагчид, Хурлын төлөөлөгчдөд 4 хос спорт хувцсыг 13.2 сая төгрөгөөр худалдан авч тараасанд зөвлөмж өгсөн.

**Увс аймгийн Чандмань-Увс ХХК:** “Чандмань-Увс” ХХК нь захирлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/46 дугаар тушаалаар компанийн шинэ жилийн баярын цэнгүүний үйл ажиллагаанд зориулан 6.8 сая, 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотоос ажлаар ирсэн хүмүүст зориулж согтууруулах ундаа худалдан авахад 0.3 сая, нийт 7.1 сая төгрөгийг компанийн төсвөөс зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 126, байршуулаагүй 2, хугацаа хоцроосон 14, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 3 мэдээлэл байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө зарцуулсан шийдвэрийг мэдээлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 14,751.9 сая төгрөгийн 115 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өглөө.

#### **Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:**

Дараах төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн шилэн данстай холбоотой зөрчилд албан шаардлага өгсөн.

- **Давст сумын Засаг даргын Тамгын газар:** Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27.8 сая төгрөгийн 2 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 19.8 сая төгрөгийн 7 шийдвэрийн мэдээлэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй;
- **Давст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 138.3 сая төгрөгийн 12 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 2.6 сая төгрөгийн 10 шийдвэрийн мэдээлэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл хөтөлбөр зориулалт, төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал, байгууллагын батлагдсан төсөв, мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан;
- **Хяргас сумын Засаг даргын Тамгын газар:** Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 61.8 сая төгрөгийн 6 зарлагын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 419.9 сая төгрөгийн 6 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 53.6 сая төгрөгийн 41 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 651.7 сая төгрөгийн 8 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27.4 сая төгрөгийн 4 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 14.1 сая төгрөгийн 5 шийдвэрийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлангийн 351.3 сая төгрөгийн 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан;
- **Цагаанхайрхан сумын Засаг даргын Тамгын газар:** Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7.9 сая төгрөгийн 1 зарлагын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 551.9 сая төгрөгийн 7 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 33.1 сая төгрөгийн 38 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 362.0 сая

- төгрөгийн 5 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.3 сая төгрөгийн 7 шийдвэрийн мэдээлэл, байгууллагын батлагдсан төсвийн 956.4 сая төгрөгийн 1 мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 569.5 сая төгрөгийн 1 мэдээлэл, дараа жилийн төсвийн төслийн 1 мэдээлэл, санхүүгийн тайлан хагас жил тутамд байршуулах 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан;
- **Увс аймгийн Чандмань-Увс ХХК:** Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 575.9 сая төгрөгийн 44 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 132.9 сая төгрөгийн 45 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 811.3 сая төгрөгийн 52 зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан;
  - **"Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан:** Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан төсөв, хөрөнгө зарцуулах, эрх шилүүлэх 5,915.1 сая төгрөгийн 27 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй;
  - **Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 327.7 сая төгрөгийн орлогын 12 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 318.4 сая төгрөгийн зарлагын 17 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 204.2 сая төгрөгийн 20 шийдвэр, санхүүгийн тайлан хагас жилийн, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй;
  - **Бөхмөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан талбарт 230.5 сая төгрөгийн 4 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 275.0 сая төгрөгийн 6 гүйлгээг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 259.1 сая төгрөгийн 21 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 259.3 сая төгрөгийн 32 шийдвэр, байгууллагын батлагдсан төсвийг байршуулаагүй;
  - **Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан талбарт 186.8 сая төгрөгийн 2 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 146.5 сая төгрөгийн 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 56.8 сая төгрөгийн 2 шийдвэр, Байгууллагын батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан тус тус байршуулаагүй;
  - **Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Шилэн дансны цахим хуудаст 602.8 сая төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 508.8 сая төгрөгийн 26 мэдээлэл байршуулаагүй;
  - **Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Шилэн дансны цахим хуудаст 643.4 сая төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 189.2 сая төгрөгийн 19 мэдээлэл байршуулаагүй;
  - **Цагаанхайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Шилэн дансны цахим хуудаст 180.5 сая төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 485.5 сая төгрөгийн 19 мэдээллийг байршуулаагүй.

Дараах төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн шилэн данстай холбоотой зөрчилд зөвлөмж өгсөн.

- **Завхан сумын Засаг даргын Тамгын газар:** Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 733.3 сая төгрөгийн орлогын 10 гүйлгээ, Цалингийн

- зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 255.3 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, 247.9 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 37 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй;
